ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.БАЯРМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. ЗОРИЛТ 3: УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ШУДАРГА, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ БҮРДҮҮЛЭХ | | | | | | | |
| 1 | Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт | Хэрэгжилт, хувиар | 99.3 | Сангийн сайдын тушаалын дагуу 2025 оны улсын төсвийн эхний хагас жилийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллана. | **Нэг.** Татварын орлогын хуваарилалт<br>Төсвийн тухай хуулийн дагуу 2025 онд гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дүнг Сангийн сайдын “Төсвийн хуваарь батлах тухай” 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 40 дүгээр тушаалыг үндэслэн ГЕГ-ын даргын 2025-02-19-ний А/91 тоот “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” тушаалыг батлуулан гаалийн газар, хороодод хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Ийнхүү сар тутамд гаалийн газар, хороодод улсын төсвийн орлогын төлөвлөгөөг хуваарилан:<br>1) ГЕГ-ын 2025-01-02-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан тоотоор Улсын төсвийн гаалийн орлогын 1 дүгээр сарын хуваарь,<br>2) ГЕГ-ын 2025-02-04-ны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/585 тоот албан бичгээр Улсын төсвийн гаалийн орлогын 2 дугаар сарын хуваарь,<br>3) ГЕГ-ын 2025-03-07-ны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/945 тоот албан бичгээр Улсын төсвийн гаалийн орлогын 3 дугаар сарын хуваарь,<br>4) ГЕГ-ын 2025-04-08-ны “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” 02-2/1397 тоот албан бичгээр Улсын төсвийн гаалийн орлогын 4 дүгээр сарын хуваарь, | 01.01-06.10 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5) ГЕГ-ын 2025-04-29-ний "Чиглэл хүргүүлэх тухай" 02-2/1769 тоот албан бичгээр Улсын төсвийн гаалийн орлогын 5 дугаар сарын хуваарь,<br>6) ГЕГ-ын 2025-06-03-ны "Чиглэл хүргүүлэх тухай" 02-2/2345 тоот албан бичгээр Улсын төсвийн гаалийн орлогын 6 дугаар сарын хуваарь.<br>Гаалийн газар, хороодод сар бүр ГЕГ-ын даргын болон Татвар, орлогын газрын даргын албан тоотоор улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хуваарийг хүргүүлэн, биелэлтэд нь хяналт тавьж ажиллаж байна. Орлогын хуваарийн тооцооллыг гаргахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан тоон мэдээлэл, судалгааны үндсэн дээр тооцдог. Үүнд:<br>- Импортын урсгалын хэмжээ, бүтэц, улирлын хэлбэлзэл<br>- Тээвэр, ложистикийн нөхцөл байдал<br>- Боомтын нэвтрүүлэх хүчин чадал, цагийн хуваарь, ачаалал<br>- Бараа, бүтээгдэхүүний шилжилт, өөрчлөлт<br>- Гаалийн газар, хорооны сүүлийн 10 жилийн гаалийн бүрдүүлэлтийн мэдээ<br>- Татварын орлогын гүйцэтгэл, төлөвлөлтийн хандлага<br>**Хоёр.** Татварын орлогын гүйцэтгэл буюу холбогдох тайлбар Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 5 сарын байдлаар Улсын төсөвт 2952.1 тэрбум төгрөг төвлөрүүлэх үүрэгтэйгээс 2732.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Гаалийн болон НӨАТ-аас төвлөрүүлэх орлого нь импортын хэмжээ, бүтэц, гаалийн үнэлгээнээс шууд хамаардаг. Импорт болон чингэлэгийн тоо буурсан, уул уурхайн хамаарах бараа /шатахуун/-ны импорт буурахын зэрэгцээ, БНХАУ-ын арматур, барилгын бүтээц төмрийн зах зээлийн үнэ буурснаар орлогын гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлсэн.<br>Гэвч өмнөх оны мөн үеэс 212.8 тэрбум төгрөгөөр илүү орлогыг төвлөрүүлсэн нь 8.4 хувийн өсөлттэй үзүүлэлттэй гарсан.<br>Импорт эхний 5 сард 4,568.1 сая ам.долларыг өмнөх оны 4,398.9 сая ам.доллартай харьцуулахад 4 хувиар өссөн бөгөөд импортын хэмжээг өмнөх оноос 15.3 хувийн өсөлттэй байхаар тооцоолсон ч төлөвлөсөн хэмжээнд хүрсэнгүй. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гэвч гадаад улс орны эдийн засаг, тарифын бодлого, худалдааны тогтворгүй, тодорхой бус байдлын улмаас экспортын хамааралтай импорт буурах хандлагатай байгаагийн улмаас дараах нөхцөл байдал ажиглагдаж байна. Үүнд:<br>Тяньжин боомт дахь чингэлэгийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1425-1500 чингэлэгийн тоогоор буурсан нь төмөр замын тээвэрлэлт бага зэрэг буурч, автозамын тээвэрлэлт бага зэрэг нэмэгдсэн.<br>Импортын бүтцэд уул уурхайн хамааралтай барааны импортын хэмжээ буурсан, барилгын гол нэрийн төмрийн БНХАУ дахь зах зээлийн үнэ буурсан. | | |
| 2 | Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90 | - Харьяа гаалийн газар, хороодын Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарийг сар тутамд батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.<br>- Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. | **Нэг**. Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр 7 хоног тутмын шуурхай хуралдаанд газар, хороодыг цаг үеийн мэдээллээр хангах, тодорхой чиглэлийн үүрэг даалгаварыг өгч, холбогдох ажлуудыг гүйцэтгэж ажилласан. Түүнчлэн харьяа гаалийн газар, хороодын сар бүрийн орлогын төлөвлөгөөний дүн шинжилгээг хүлээн авч, нэгтгэж удирдлагад танилцуулсан.<br>**Хоёр**. Улсын төсөвт 2024 онд төвлөрүүлэх орлого 59.7 тэрбум төгрөгөөр тасарсанд дүгнэлт хийж, холбогдох судалгааг хийхэд Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримт хариуцсан гаалийн улсын байцаагч нар “Бичиг баримтын шалгалт хийгдсэн” төлвийн дараа барааны гаалийн үнийг бууруулан үнэлсэнээр дахин нэхэмжлэх үүсгэж, 2024 оны байдлаар нийт 7192 мэдүүлэгт 247.8 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан гэх дүгнэлт хийхэд хүргэсэн. Иймд уг асуудлыг ГЕГ-ын дарга, дэд дарга нарт танилцуулж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгосон:<br>• Бичиг баримт хариуцсан ГУБ нарыг гаалийн үнийг өөрчлөх буюу “Дахин нэхэмжлэх” үүсгэх боломжийг Кайс системд хаах.<br>• Үнэлгээтэй холбоотой журам, заавартт нэмэлт өөрчлөлт оруулах. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, системд шийдвэрийн талаарх мэдээллийн санг бий болгох,<br>Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр улсын төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.<br>Дэд даргын баталсан удирдамжийн дагуу ХБГ-ын ГУАБ Ариунцэцэг бүхий гишүүдийн бүрэлдэхүүн ажиллаж, 2024 оны болон 2025 оны эхний 4 сарын байдлаарх мэдээлэлд дүн шинжилгээг хийж, үр дүнг Бүрдүүлэлтийн цахим төвд танилцуулж, анхааруулж, цаашид алдааг дахин давтан гаргахгүй байх чиглэлд ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгохын зэрэгцээ Кайс системд холбогдох хөгжүүлэлтийг МТГ-аас хийж байна.<br>**Гурав**. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:<br>Гаалийн ерөнхий газраас газар, хороодын орлогын гүйцэтгэлийг сар бүр хянаж, татварын орлогын төлөвлөгөө тасарсан шалтгаан, биелэлтийг хангах чиглэлд анхаарах асуудлыг нь тодорхойлж чиглэл өгөх, дэмжин туслах, зааварлаж чиглүүлэх, мэдээллээр хангах зэрэг шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.<br>**Дөрөв.** Сангийн сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу гаалийн байгууллага нь 2025.04.04-ны өдрөөс эхлэн Төсвийн орлогын гүйцэтгэлийн явцыг 7 хоног бүрийн Баасан гаригт Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар болон Төсвийн орлогын хэлтэст тогтмол танилцуулж, холбогдох мэдээллээр хананган ажиллаж байна.Тайлагнал дараах бүтэцтэй байна.<br>• Орлогын дүн (үндсэн болон нийт орлого)<br>• Импортын барааны бүтэц тус бүрээр гүйцэтгэл<br>• Өмнөх 7 хоног болон өмнөх оны мөн үетэй харьцуулалт<br>• Орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн гол хүчин зүйлүүдийн товч тайлбар.<br>**Тав.** Сангийн сайдын 2024 оны 22 дугаар тушаал "Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | биелэлтийг хангуулах тухай"- ын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайлангийн биелэлтийг 2024 оны жилийн эцсээр гарган ГЕГ-ын 2025-01-15-ний 02/214 албан тоотоор хүргүүлсэн. Хавсралт 9 хуудастай.<br>**Зургаа.** Сангийн сайдын 2025 оны 18 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний дагуу Гаалийн байгууллагын 2025 онд авч хэрэгжүүлэх /7 чиглэлийн ажилд 26 арга хэмжээ/ төлөвлөгөөний төслийг боловсруулан танилцуулж, ГЕГ-ын даргаар батлуулан, биелэлтийг хариуцсан зохион байгуулалтын нэгжээс авч нэгтгэн сар бүрийн 10-ны дотор СЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.<br>Гаалийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраар улирал бүр тайланг хянуулах тухай төлөвлөгөөнд тусгасны дагуу 2025 оны 1 дүгээр улирлын тайланг хянуулж, 83 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн.<br><br>- Сангийн яамны шуурхай дээр Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг ГЕГ-ын шуурхай хуралдаанд ЗББНДБ-ын дарга нар болон гаалийн газар, хороодод мэдээллийг хүргүүлж, үүрэг даалгаварыг тухай бүр өгч, тодорхой ажлуудыг гүйцэтгэж ажилласан.<br>- ГЕГ-ын даргын 2025.04.16-ны өдрийн А/152 дугаар тушаалаар "Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд"-д тусгагдсан Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулахад мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гарган ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг, мөн Статистик мэдээлэлд суурилсан дүн шинжилгээг хийж, тайлагнан ажиллах багийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн ахалсан Дэд дарга "Ажлын хэсэг, Дүн шинжилгээний багийн бүрэлдэхүүн" болон харьяа гаалийн газар, хороодын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр 2 удаа, ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр 3 удаа хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. ГЕГ-ын даргад 2025 оны эхний 5 сарын байдлаарх танилцуулгыг бүрэн бүрэлдэхүүнээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулан, цаашид анхаарвал зохих асуудал, чиглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>--- Сангийн сайдын өгсөн үүрэг чиглэлийн дагуу "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний /5 чиглэлийн 41 арга хэмжээ/ төслийг боловсруулан ГЕГ-ын даргаар 2025.04.07-ны өдөр батлуулан, бүх нэгжүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг 2025.05.30-ны өдрийн байдлаар хариуцсан ГЕГ-ын ЗББНДБ-ууд болоон харьяа гаалийн газар, хороодоос биелэлтийг хүлээн авч нэгтгэн ГЕГ-ын удирдлагад танилцуулсан. Төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав. | | |
| 3 | Улсын төсвийн гаалийн орлогын төсвийн төслийг хүргүүлэх, мэдээ, тайлан дүн шинжилгээг сар бүр гаргаж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон удирдлагад хүргүүлж мэдээллээр хангасан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | - Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээг 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1, 2, 3, 4, 5 дугаар саруудын мэдээг сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, экспортын эрдэс бүтээгдэхүүний мэдээ, эрдэс бүтээгдэхүүн экспортлогч ААН-ийн импортын татварын мэдээг нэгтгэж, УИХ-ын Тамгын газар болон Сангийн яам, удирдлагуудад | **Нэг**. УИХ-ын Тамгын газар, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтэст Улсын төсвийн орлогын дүн шинжилгээ бүхий статистик мэдээг сар бүр хүргүүлэн ажиллалаа. Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээ 2024 он, 2025 оны 1 - 05 сард тус бүрээр боловсруулж хүргүүлсэн. Ингэхдээ төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, хавсралт статистик мэдээллүүдийг багтаадаг болно.<br>**Хоёр**. Үндэсний аудитын газраас 2024 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийгдэж буйтай холбогдуулан Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөн дараах мэдээллийг албан тоотоор хүргүүлсэн. Үүнд:<br>- ГЕГ-ын 2025-06-04-ний 02/2370 албан тоотоор Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж даргад ашигт малтмалын ордыг ашиглаж байгаа ААНБ-иудын мэдээлэл,<br>- ГЕГ-ын 2025-06-04-ний 02/2371 албан тоотоор Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж даргад уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортолж, улсын төсөвт татварын орлого бүрдүүлдэг ААНБ-иудын мэдээлэл<br>Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээг 2024 оны жилийн эцэс, 2025 оны 1, 2, 3, 4, 5 дугаар саруудын мэдээг сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж, төсвийн орлогын | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргүүлсэн байна. /I-II улиралд / | төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, экспортын эрдэс бүтээгдэхүүний мэдээ, эрдэс бүтээгдэхүүн экспортлогч ААН-ийн импортын татварын мэдээг нэгтгэж, УИХ-ын Тамгын газар болон Сангийн яам, удирдлагуудад хүргүүлж, холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. | | |
| 4 | Улсын төсвийн гаалийн орлогын хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэх, хүргүүлэх, хугацаа хэтэрсэн татварын өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа гаргах, түр горимын дансны үлдэгдлийн хяналт зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавих | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | - Гаалийн байгууллагын татварын орлогын 2024 оны жилийн эцсийн тайланг газар, хороодоос хүлээн авч, нэгтгэн нэгтгэсэн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.<br>- Сангийн яамны Төрийн сангийн газарт гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор буюу хугацаанд нь 5 удаа гаргаж, цахимаар болон тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулсан байна.<br>- Хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах, | **Нэг.** Төсвийн орлогыг төвлөрүүлж буй гаалийн болон бусад татварын ногдуулалт, барагдуулалтанд бүртгэлээр хяналт тавьж Кайс, Epayment-ийг харьцуулан, Төрийн сангийн дансны хуулгыг өдөр тутам татан авч боловсруулж, орлогын гүйцэтгэлийн мэдээг ажлын өдөр бүр гаргаж удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.<br>Сангийн яамны Төрийн сангийн газарт Гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 8-ны дотор буюу хугацаанд нь цахимаар болон тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулан ажилласан.<br>Улсын төсөвт 2024 онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийг харьяа 19 газар, хороодтой тооцоо нийлж, тулган баталгаажуулан хүлээн авч татвар, хураамж, өөрийн орлого, түр горимын нэгтгэл тайланг гаргаж, баталгаажуулан Төрийн сангийн газарт хуулийн хугацаанд нь хүргүүлэн нэгтгүүлсэн.<br>Төсөвт төвлөрүүлсэн орлогыг төрөл тус бүрээр гаалийн газар, хороодтой сар бүр тооцоо нийлж, баталгаажуулан татвар, хураамж, өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн мэдээг газар, хороодоор гаргаж, гаалийн байгууллагын "Захиргааны статистик мэдээлэл"-д оруулахаар Статистик, дүн шинжилгээний хэлтэст сар бүр хүргүүлсэн.<br>**Хоёр.** Түр горим: Гаалийн бүрдүүлэлтийн "500" горимд байршуулсан барааны татварын дансны үлдэгдэлийн мэдээг газар, хороодоос хүлээн авч хяналт тавьж, холбогдох чиглэл хүргүүлэн ажилласан. Мөн гаалийн бүрдүүлэлтийн "507" горимд хугацаа хэтэрсэн, хаагдаагүй мэдүүлгүүдийн 2010-2023 оны байдлаарх мэдээллийг гаргаж, энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинээр хугацаа хэтэрсэн өр авлага үүсгэхгүй байх, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа, түр горимын дансны үлдэгдэл, арилжааны банкны гэрээнд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавьж ажилласан байна. | А/50 дугаар тушаал "Ажлын хэсэг байгуулах тухай" -ыг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.<br>**Гурав**. Хойшлуулалт: ЗГ-ын шийдвэрээр хойшлуулсан татварын дүнд системээс хяналт тавьж, мэдээг сар бүр гарган СЯ, удирдлагыг мэдээллээр хангасан.<br>**Дөрөв**. Өр авлагын барагдуулалт: 2024 оны жилийн эцэст 34.9 тэрбум төгрөгийн хойшлуулсан татварын авлагын үлдэгдэлтэй байсан бөгөөд өрийг барагдуулахаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласаны дүнд 16.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болгож, өрийг 18 тэрбум төгрөгөөр бууруулсан.<br>**Тав.** Буцаан олголт: Улсын их хурлын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор 53 аж ахуйн нэгжийн 2024 онд ногдуулсан гаалийн албан татвар болох 6.7 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг буцаан олгохтой холбогдох хүсэлтийг хүлээн авч, бичиг баримтыг нягтлан тулгах шалгах ажлыг 2025 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, Сангийн Яамны Төсвийн орлогын хэлтэс болон Төрийн сангийн газарт мэдээллийг хүргүүлэн ажилласан.<br>"Лекс ойл" ХХК-ийн онцгой албан татварын буцаалтаар гаалийн байгууллагаас 26.0 орчим тэрбум төгрөгийг гаргуулан авахаар 2024.12.03-ны өдрийн хүсэлт ирүүлсэнийг Сангийн яамны ТНБ-д албан тоотоор мэдэгдэж, хариуг авсаны дагуу тус компанид хариуг хүргүүлсэн. Гэвч "Лекс ойл" ХХК-иас Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гарган ГЕГ-ыг хариуцагчаар татсан, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ГУАБ Эрдэнэбат, ГУБ Оюунжаргал, Хуулийн хэлтсийн ГУБ Лувсандорж нар шүүх хуралд оролцож байна.<br><br>**Зургаа**. ГГХ-д болон БЦТ-д Нефть бүтээгдэхүүнтэй холбогдуулан ЗГ-ын 2024.12.25-ны өдрийн 241, 242 тоот тогтоол "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" -ын хэрэгжилтэд ГГХ-д 1-р сарын орлогын хуваарийг хүргүүлсэнийг танилцуулахын зэрэгцээ УИХ-ын 2024.12.12-ны өдрийн хуулиар ГТГТТХ-д оруулсан нэмэлт өөрчлөлт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засгийн газрын 241, 242 тогтоол зэрэг 2025.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжих эрх зүйн акт, ГГХ-д болон БАУХ, БЦТ-д "Чиглэл хүргүүлэх тухай" тоотоор хяналт тавьж ажиллах чиглэлийг хүргүүлсэн. | | |
| 5 | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | 100% | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөн бүрмөсөн болон түр хугацаагаар орох гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх, мэдээллийг ил тод болгох, хяналт тавьж, зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна. | **Нэг.** Татварын чөлөөлөлтийн чиглэлээр: Тайлант онд Гаалийн газар, хороодод татварын чөлөөлөлттэй холбоотой хэрэгжүүлэх хууль тогтоомж буюу баримтлах чиглэлийг 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02/17 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 240 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 02-2/573 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2023 оны 107 дугаар тогтоолын дагуу хөнгөлөлтөд хамрагдах Аж ахуйн нэгжийн "үндсэн хөрөнгөнд бүртгэгдсэн тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг буцаан олгох" -той холбогдуулан Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газартай 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр уулзалтыг зохион байгуулж, харилцан мэдээлэл солилцсон. Мэдээлэл солилцсоны үр дүнд Сангийн яаманд хүсэлт гаргаж, цахим системд ААН-ийн санхүүгийн тайлан харах эрхийг авснаар "үндсэн хөрөнгөд бүртгэгдсэн эсэх"-ийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулахад хялбар, цаг хугацаа алдахгүй, маргаан гаргахгүй байх боломжийг бүрдүүлж ажилласан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан татварын чөлөөлөлтэд учирч буй хүндрэл бэрхшээлийн асуудлаар ГБХНХЯ-ны сайдад 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/68 тоот албан бичиг хүргүүлсэн бөгөөд тус яаманд холбогдох чиглэлийн нэгжийн удирдлага, албан хаагч нартай ТОГ-ын дарга, татварын чөлөөлөлт хариуцсан 2 ГУБ, барааны ангилал хариуцсан ГУБ-ийн хамт уулзалтыг зохион байгуулж, цаашид нийгмийн хамгааллын болон гаалийн тухай хууль тогтоомжид тодорхой заалтыг нэмэлт өөрчлөлтөөр оруулах саналыг бодлогын яам гаргах нь зүйтэй гэдэгт санал нэгдсэн.<br>Аж ахуйн нэгж, байгууллагаас гаалийн болон бусад татвараас чөлөөлөх хүсэлтийг edoc.ecustoms.mn цахим хуудсаар ирүүлсэн 281 хүсэлтийг шийдвэрлэж, аж, ахуйн | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгж байгуулага болон гаалийн газар,хороод руу 168 албан бичиг хүргүүлсэн.<br>Гадаадын зээл, тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх тухай албан хүсэлтийг https://odamis.mof.gov.mn цахим хуудсаар Сангийн яам хянасан нийт 513 бүртгэлийн хуудас хүлээн авч, цахим баталгаажуулан 483.6 сая ам.долларын бараанд ногдох 8.3 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 18.2 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар, нийт 26.5 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн байна.<br>Гаалийн газар, хороод болон Бүрдүүлэлтийн цахим төвд шинээр батлагдсан болон одоо мөрдөгдөж буй татварын чөлөөлөлттэй холбоотой хууль тогтоомжийн талаар хоёр удаа чиглэл хүргүүлсэн.<br>Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 368 аж, ахуйн нэгж, 3 иргэний импортолсон нийт 293.4 сая ам.долларын бараанд ногдох 53.2 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 75.5 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар, нийт 129.1 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн.<br>**Хоёр.**Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд "Чоногол трейд" ХХК өмнөх онд төлсөн 207.0 сая төгрөгийн татварыг татварын чөлөөлөлтөд хамруулж, гаалийн байгууллагаас гаргуулахаар нэхэмжлэл гаргасанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр татварын чөлөөлөлт хариуцсан ГУБ Базарваань шүүх хуралд оролцож, гаалийн байгууллагын талд шийдвэрийг гаргуулсан.<br>**Гурав**.Сангийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02-2/354 тоот албан бичгээр 2024 оны төсвийн зарлагын мэдээг хүргүүлсэн. ХББОСЯ-нд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн 2024 оны татварын чөлөөлөлтийн мэдээг гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02-2/395 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>УИХ-ын Татварын багц хуулийн Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Х.Ганхуягийн үүрэг болгосоноор ГТГТТХ-ийн дагуу 2024 оны байдлаарх татварын чөлөөлөлт, хөнгөлөлтийн 2022,,2023, 2024 оны байдлаарх мэдээллийг гаргаж,. СЯ-ны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүнд хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Дөрөв.** 2024 онд гаалийн бүрдүүлэлтийн “400” горим буюу “330” хэлцлийн кодоор бүрдүүлэлт хийгдсэн ЗГ-ын 107 дугаар тогтоол “Импортын барааны гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалт”-д хамаарах тоног төхөөрөмж импортолсон 180 гаалийн бүрдүүлэлт хийсэн 53 аж, ахуйн нэгжийн 6.7 тэрбум төгрөгийн гаалийн татварын хөнгөлөлтийг буцаан олгох ажлыг шуурхай, хүндрэл чирэгдэлгүй зохион байгуулсан. **Тав**.Гаалийн бүрдүүлэлтийн "507" горимд байршуулсан ч хугацаа хэтэрсэн бүрдүүлэлтийн мэдээг гарган хяналт тавьж буй гаалийн газар, хороодод авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг хүргүүлж ажилласан. Нийт 331 мэдүүлгээс 118 мэдүүлэг буюу 35.6 хувийг бүрэн шийдвэрлэсэн бөгөөд үүнээс, 75 мэдүүлгийг CAIS программ дээр бүрэн хааж, БДШ-аар акт тавигдан татвар,торгууль бүрэн төлөгдсөн болович Кайс программд хаалт хийгдээгүй байсан 43 мэдүүлгийг хаасан. Ийнхүү ГЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг зохион байгуулалтын арга хэмжээг авсаны үр дүнд гаалийн бүрдүүлэлтийн “507” горимоос дараагийн горимд барааг байршуулах бүрдүүлэлтийг хийлгэж, 178,816,468.37 төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br><br>ХХААХҮЯ, БОУАӨЯ, ХББОСЯ-нд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд хугацаа хэтэрсэн “507” горимын талаарх мэдээллийг хүргүүлсэн. /02/358, 02/338, 02/339 албан тоотуудаар/ “УБТЗ” ХНН-д 2025.03.24-ны өдрийн 02/1164 тоот албан бичгээр “Мэдэгдэл” 507 горимын хугацаа хэтэрсэн талаар хүргүүлсэн. 2025.06.04 өдрийн 02/2383 тоот албан бичгээр 8 гаалийн газарт гаалийн бүрдүүлэлтийн “507” горимын хугацаа хэтэрсэн ч хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй аж, ахуйн нэгжүүдийг Хуулийн хэлтэстэй хамтран хууль, шүүхийн байгууллагад баримтыг шилжүүлэх чиглэлийг хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | | - Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, харьяа гаалийн газар, хороодыг зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна.<br>- Дэлхийн худалдааны байгууллагад тухайн жилийн тарифын жагсаалтаа хянуулахаар хүргүүлсэн байна. | **Нэг.** МУ болон Япон Улс хооронд байгуулсан ЭЗТХэлэлцээр 2016 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор МУ-ын гаалийн тарифын ангилалд шинэчлэл хийгдэж, гурван төрлийн гаалийн тарифыг хэрэгжүүлэх зохицуулалт бий болсон.<br>Энэхүү өөрчлөлтийн хүрээнд 2015 оноос эхлэн гаалийн бүрдүүлэлтийн CAIS системд гаалийн тарифын ангиллыг (ердийн, нэн тааламжтай, хэлэлцээрийн тариф) гэсэн 3 төрлөөр оруулсан. Мөн ДХБ-ын гишүүн 166 орон болон гишүүн бус улс орнуудын жагсаалтыг системд бүртгэж, ДХБ-ын гишүүн бус улс орноос импортолсон бараанд ердийн тариф автоматаар сонгогдон хэрэгжих тохиргоог тус тус нэвтрүүлсэн. Ингэснээр гаалийн тарифыг зөв, алдаагүй сонгох нөхцөл бүрдсэн юм.<br>Хөнгөлөлттэй тарифын хэрэгжилтийн хүрээнд Япон Улс, Монгол Улс хоорондын ЭЗТХ-ийн хүрээнд 2025.01.01-2025.05.31 хүртэлх хугацаанд нийт 46 ААНБ, 134 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 24.6 тэр.бум төгрөг, АНДХХ-ийн хүрээнд нийт 4 ААНБ, 4.6 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 88.8 сая төгрөгийн хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн байна.<br>Япон Улс, Монгол Улс хоорондын ЭЗТХ-ийн хүрээнд 2025.05.01-ний өдрөөс эхлэн гарал үүслийн баримтыг цахимаар солилцож эхэлсэн.<br>Манай улсад гарал үүслийг нотлох баримт бичгийг цахимжуулах ажил үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд энэ чиглэлээр МХАҮТ болон МТГ-тай хамтарсан уулзалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>Монгол Улс, БНСУ-ын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн тав дахь үе шатны хэлэлцээг угтах бэлтгэл ажлын хүрээнд ЭЗХЯ-д болон МХАҮТ-т зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>Мөн Монгол Улс, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн (ЭЗТХ) 5 дахь үе шатны завсрын уулзалт 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Гадаад харилцааны яаманд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд энэхүү хэлэлцээнд гаалийн байгууллагын төлөөлөл оролцсон болно. | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дэлгэрэнгүй тайланг файлаар хавсаргав: Файлын нэр - /ГТ,ГҮГ хагас жил тайлан 2025 он/<br>**Хоёр.** ДХБ-ын Тариф, худалдааны мэдээллийн нэгдсэн цахим санд оруулах МУ-ын 2025 оны импортын барааны гаалийн нэн тааламжтай (6375 "TL-tariff line") - 214 хуудас, хөнгөлөлттэй тарифын мэдээлэл EPA ( 6350 TL ) – 249 хуудас; APTA (388 TL) 21 хуудас; нийт 1170 хуудас жагсаалтыг нэгтгэн албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн.<br>**Гурав**. ГТХ,ГТГТТХ-д нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд гарал үүсэл, тарифын чиглэлээр саналыг боловсруулж Хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>Дэлгэрэнгүйг хавсаргав: Файлын нэр - ГТ,ГҮГ хагас жил тайлан 2025он Олон талт болон хоёр талт хэлэлцээр, ГТХ,ГТГТТХ-д нэмэлт өөрчлөлт орсон тухай бүрд гаалийн бүрдүүлэлтийн CAIS системд тарифын шинэчлэлтийг үе шаттайгаар хийж хэрэгжүүлж байна.<br>Гаалийн тариф болон бусад татварын хувь хэмжээ, хөнгөлөлттэй тарифын өөрчлөлтийн мэдээллийг тухай бүрд нь автоматжуулсан системийн тарифын сан (CAIS, CIMS программ)-д оруулсан. Үүнд:<br>"Монгол Улс, Япон Улстай байгуулсан ЭЗТХ-ийн дагуу 2025.04.01 өдөр А, В ангилалд хамаарах барааны тарифын хөнгөлөлтийн өөрчлөлт.<br>Экспортын барааны тарифын хувь хэмжээг CIMS системд оруулсан.<br>Архи согтууруулах ундаанд ногдуулах ОАТ-ын тарифын хувь хэмжээний өөрчлөлтийг тус тус оруулсан.<br>**Дөрөв**. ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалаар баталсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ын 6 дугаар заалтын дагуу 2024 оны 4-р улирал болон 2025 оны 1-р улиралд Нэн тааламжтой тариф болон хөнгөлөлттэй тарифад хамрагдсан барааны гаалийн бүрдүүлэлтийн гарал үүслийг нотлох баримт бичгийг нягтлан шалгасан мэдээлэлд дүн шинжилгээг хийсэн.<br>ДГБ-ын гишүүн улс орнууд болон ЕАЭС-ийн гишүүн орнууд гарал үүслийг нотлох баримт бичгийг бүрэн цахимжуулж, тухайн гишүүн улсын дотор цахимаар баталгаажуулдаг тул цаасан хэлбэрээр олгодоггүй байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цаашид “нэн тааламжтай тарифыг хянах” чиг үүргийг бодлогын түвшинд хариуцах ажлаас хасуулах саналтай байна. | | |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 100% | Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Тайлант хугацаанд Сангийн яамны ТНБ-ийн даргын 2025.01.07-ны 03/79 тоот “МУИХ-ын 2024.08.27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д заасны дагуу татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ГЕГ-ын дарга, дэд дарга, ТОГ-ын дарга нар орсон тул .Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн хүргүүлсэн.<br><br>Хуулийн төсөлд оруулсан саналууд:<br><br>1.Гаалийн татварын маргаан таслах зөвлөл байгуулах:Гаалийн тухай хуульд мэдүүлэгчээс гаалийн болон бусад татвартай холбоотой гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий "Гаалийн татварын маргаан таслах зөвлөл"-ийг байгуулж, тус зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, гомдол гаргах, шийдвэрлэх зэрэг зохицуулалтыг тусгасан.<br><br>2. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8.9 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах.<br><br>3. Барааны ангилал, үнэлгээ, гарал үүслийн урьдчилсан шийдвэр гаргах зохицуулалт:<br><br>Гаалийн байгууллагаас гаргах барааны ангилал, гаалийн үнэлгээ, гарал үүслийн урьдчилсан шийдвэр, тэдгээртэй холбоотой зохицуулалтын заалтуудыг тусгасан бүлэг заалтуудыг оруулсан.<br><br>4. Гаалийн үнийн ил тод байдал, үнийн хяналтын стратеги: | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Гаалийн үнийг ил тод байдлыг хангах, үнийн хяналтын стратегийн талаар холбогдох заалтуудыг тусгасан.<br><br>Татварын багц хуулийн хэлэлцүүлэгтэй уялдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.ГТХ-ийн 97.1 зүйл болон ГТГТТХ-ийн 38 дугаар зүйлд оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлж ажилласан. Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. | | |
| 8 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 100% | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллаж, хугацаанд нь тайлагнасан байна. | **Нэг.** Татварын ерөнхий хуулийн дагуу албан татварыг ногдуулахдаа дараах эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1. УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоол,<br>2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль<br>3. Онцгой албан татварын тухай хууль, болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актууд.<br>Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.5 дахь заалтын дагуу 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар:<br>Гаалийн албан татвар 0.78 их наяд төгрөг,<br>НӨАТ 1.78 их наяд төгрөг,<br>Автобензин дизель түлшний албан татвар 10.6 тэрбум төгрөг<br>ОАТ 384.64 тэрбум төгрөгийн татварыг тус тус төвлөрүүлсэн байна.<br>**Хоёр.** Засгийн газрын 2022-09-05 -ны өдрийн Дугаар 2022_335 -р тогтоол “Албан татвар хэсэгчлэн төлүүлэх тухай”, “ Журам батлах тухай” 2023-09-13-ны өдрийн Дугаар 2023_337 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг сар, улирлаар гарган Хуулийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.<br>Сангийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02-2/354 тоот албан бичгээр 2024 оны төсвийн зарлагын мэдээг хүргүүлсэн. Хуулийн хэлтэст татварын чөлөөлөлтийн хэрэгжилтийн мэдээг сар бүрээр гаргаж хүргүүлсэн.<br>ХББОСЯ-нд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн 2024 оны татварын чөлөөлөлтийн мэдээг гаргаж 2025 оны 01 дүгээр | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 24-ний өдрийн 02-2/395 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>**Гурав.** ГТГТТХ-ийн 4.2 дахь хэсэгт заасанаар импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй гэж ангилах бөгөөд Япон Улс, Монгол Улс хоорондын ЭЗТХ-ийн хүрээнд 2025.01.01-2025.05.31 хүртэлх хугацаанд нийт 46 ААНБ, 134 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 24.6 тэр.бум төгрөг, АНДХХ-ийн хүрээнд нийт 4 ААНБ, 4.6 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 88.8 сая төгрөгийн гаалийн татварын хөнгөлөлтийг тус тус үзүүлсэн байна.<br>**Дөрөв**. ГЕГ-ын Захиргаа, удирдлагын газар болон Хуулийн хэлтэст сар бүр УИХ, Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, биелэлтийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. | | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж ажилласан байна. | **Нэг**. Тайлант хугацаанд Ceгр программаар нийт 17 үүрэг даалгавар, зөвлөмжийг ТОГ-т ирүүлснээс хугацаа нь болсон 15 үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг оруулж холбогдох нэгжээр дүгнүүлсэн болно. Хугацаа нь болоогүй 2 ажлын биелэлтийг ханган ажиллаж байна.<br>**Хоёр.** Газрын даргаас 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн онлайн хурлаар харьяа 19 газар хороонд өгөгдсөн 2024 оны төсвийн жилийн эцсийн тайлан баланс нэгтгэхтэй холбоотойгоор 2024 оны ногдуулалтыг 01 дүгээр сард багтаан тулгаж дуусгах, орлогын тооцоог бүрэн нийлж 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайланг нэгтгүүлсэн байх гэсэн үүрэг даалгаварыг өгсөний дагуу газар хороодоос хүлээн авч, биелэлтийг дүгнэн баталгаажуулсан.<br>**Гурав.** "Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн"-д:Панел хэлэлцүүлэг № 6 Сэдэв. “Татварын орлогын төлөвлөгөөг хэрхэн үр дүнтэй бүрдүүлэх вэ, шийдэл” бэлтгэлийг ханган оролцсон.<br><br>**Дөрөв.** УИХ-ын даргын 2024 оны 292 дугаар Захирамжаар байгуулагдсан Ажлыг хэсэг, УИХ-ын Төсвийн байнгын хороо “Монгол Улсын Татварын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага” Цуврал хэлэлцүүлгийн 2025.01.30-ний 09-12 цагт “Их Эзэн Чингис Хаан Танхимд болох “НӨАТ-ын тухай хуулийн хэлэлцүүлэгт | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дэд даргын тавих Гаалийн байгууллагын өнөө болон цаашид хэрэгжүүлэх танилцуулгыг бэлтгэж, танилцуулсан бөгөөд Хэлэлцүүлэгт хамт оролцсон.УИХ-ын гишүүн Х.Ганхуяг ахалсан /УИХ-ын 9 гишүүн/ Төрийн ордоны Сүхбаатар танхимд Татварын багц хуулийн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуралдсан хуралд оролцож 2025.01.27-2025.02.07-ны хооронд хийгдэх ажлын чиглэлийг авсан.УИХ-ын чуулганаар Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан ГТГТТХ-д барааны ангилал, үнэлгээ, гарал үүсэл, тариф, БДШ-ын чиглэлээр өөрчлөлт оруулах эсэх талаар Татварын бодлогын газрын Тэлмүүн даргатай уулзаж чиглэл авсан.<br><br>Сангийн яамны ТНБ-ийн даргын 2024.01.10-ны 03/183 тоот "Чиглэл хүргүүлэх тухай" болон дээрх чиглэлийн дагуу ГЕГ-ын даргын баталсан төлөвлөгөөг Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн УБ хотын Худалдааны танхимаас зохион байгуулсан "Татварын шинэчлэл-Хувийн хэвшлийн оролцоо" Хэлэлцүүлэгт ХШҮДАГ-ын дарга, БАҮХ-ийн ГУАБ, ОНХА-ны ГУБ нар оролцсон.<br><br>ГЕГ-ын баталсан "Татварын хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, санал боловсруулах нэгдсэн төлөвлөгөө"-ний 7-д тусгагдсан "ГТГТТХ-ийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эрх зүйн үр нөлөөг үнэлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх" ажлыг хийхтэй холбогдуулан ХШҮДАГ болон Хуулийн хэлтэст чиглэл хүсэж, дотоод зурвасыг хүргүүлсэн.<br><br>**Тав**. ТОГ-аас 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр СЕРП программаар "ГЕГ-ын даргын 2025.04.07-ны өдөр баталсан Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөөний дагуу 2025 оны 04, 05 дугаар сарууддад хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлэх чиглэлийг ГЕГ-ын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох ЗББНДБ-ууд болон харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн. Тайлагналт нь төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажил , арга хэмжээний үр дүнд улсын төсөвт нэмж төвлөрүүлсэн орлого, цаашид анхаарах асуудал зэргийг тодорхойлсон байх шаардлагатайг дурдаж үүрэг даалгавар өгсөн болно. Энэхүү үүрэг даалгаврын биелэлтийг хүлээн авч дүгнэн баталгаажуулсан.<br>**Зургаа.** Үндэсний аудит, нийслэлийн аудитын шалгалтын бүрэлдэхүүнд татварын чөлөөлөлтийн хууль тогтоомжийн талаарх мэдээллийг гарган хүргүүлсэн.<br>ҮАГ-аас 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийгдсэн АУДИТ-д татварын чөлөөлөлт, орлогын мэдээлэл, түр дансны үлдэгдэл, татварын хойшлуулалт зэрэг мэдээлэлийг тухай бүр гаргаж хүргүүлж, тодруулга, тайлбар танилцуулга хийж ажилласан.<br>Сангийн яамны нэгтгэл тайланд орсон Үндэсний аудитад 2024 оны жилийн эцсийн татварын орлого гүйцэтгэлийн тайлан, татварын хойшлуулалтаас үүссэн өр авлагын судалгаа, авлагын дэлгэрэнгүй болон түр горимын судалгаа мэдээг гаргаж хүргүүлэн танилцуулсан.<br>**Долоо.** ТОГ-аас 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороодод гарал үүслийн бичиг баримтыг нягтлан шалгах, гаалийн үнэ үнэлгээ, хил орчмын үнийн судалгаа хийх зэрэг 5 үүрэг даалгаврыг өгч биелэлтийг хүлээн авч дүгнэн баталгаажуулсан.<br>**Найм**.Тайлант хугацаанд Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас ТОГ-т өгсөн нийт 17 үүрэг даалгавраас хугацаа болсон 15 ажлын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.<br>**Ес.** СЯ-ны шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох бүтцийн нэгж болон харьяа гаалийн газар, хороодоос авч нэгтгэн, дүн шинжилгээ танилцуулга бэлтгэн тухай бүр хүргүүлэн ажиллалаа. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Арав.** Гаалийн ерөнхий газрын дэд даргын баталсан "Гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих, гарал үүслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх ажлын төлөвлөгөө"-ний хүрээнд газар хороодод хөнгөлөлттэй гарал үүслийн гэрчилгээтэй бараанд хяналт тавьж ажилласан.<br>**Арван нэг**. БНСУ-ын Засгийн газраас хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд түнш орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх бодлогын хамтарсан судалгаа хийх, хөгжлийн талаар зөвлөгөө өгөх, чадавхыг бэхжүүлэх үүднээс "Мэдлэг хуваалцах хөтөлбөр" буюу өөрийн улсын хөгжлийн туршлагаас хуваалцах хөтөлбөрийн хүрээнд Солонгосын хөгжлийн хүрээлэн (KDI) болон Солонгосын жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн агентлаг (KISME)-ийн судалгааны баг, Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны холбогдох удирдах албан тушаалтнуудын хамтаар хөтөлбөрийн дагуу Гаалийн ерөнхий газарт ирж ажиллахад:<br><br>Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, Барааны ангилал үнэлгээний хэлтсийн дарга Ч.Чимгэрэл, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө.Цолмон, Статистик дүн шинжилгээний хэлтсийн дарга Б.Баясгалан, Хяналт, бүрдүүлэлтийн газрын ГУАБ Ц.Цэвээндарь, Эрсдлийн удирдлагын хэлтсийн ГУАБ Ц.Болор-Эрдэнэ, Статистик дүн шинжилгээний хэлтсийн ГУБ Д.Нямдагва, Б.Эрдэнэбулган нар оролцсон.<br><br>**Арван хоёр**.ГЕГ-ын даргын баталсан Гаалийн цом-2025 спорт арга хэмжээний хүрээнд ГЕГ-ын бүтцийн нэгжүүдийн хооронд зохион байгуулагдсан тэмцээнд газрын хамт олон бүрэн хамрагдаж, идэвхтэй оролцсон. Мөн теннис төрлийн тэмцээнийг хариуцан зохион байгуулж, шагналт байрт орсон тамирчдад шагналыг гардуулсан.<br><br>**Арван гурав**.ГХЯ-аас зохион байгуулсан "Ази, номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн гишүүдийг ЗҮ боомтод ажиллуулахад ГУАБ Эрдэнэбат оролцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ажлын хэсгийн гишүүдийг хил дамнасан худалдааны үйл явц, саад бэрхшээлийг судлах, гааль, тээвэр, ложистикийн байгууллагуудтай холбогдох уулзалтыг хийлгэж, санал солилцуулах зорилготой.<br><br>**Арван дөрөв**. ЗУГ, ХШҮДАГ-ын хамтран **2025.06.05-ны** өдөр зохион байгуулсан "Гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлагналт, анхаарах асуудал" сэдэвт ГЕГ-ын даргын баталсан Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад ГУАБ, төлөвлөгөө, тайлан хариуцсан ГУБ нарын хамт оролцож, холбогдох мэдээлэл, сургалтыг авсан бөгөөд газрын ГУАБ, ГУБ нарт холбогдох ЗГ-ын тогтоол, Сангийн сайдын тушаал, ГЕГ-ын даргын тушаалын дагуу 2025 оны эхний хагас жилийн тайланг тайлагнахдаа төлөвлөлтийн дагуу биелэлтийн гүйцэтгэлийг тоон мэдээллээр илэрхийлж, холбогдох файлыг хавсаргах, өмнөх алдааг дахин гаргахгүй байхад анхаарч, ажлын гүйцэтгэлийг үнэлэхүйц бодитой, тодорхой 5С зарчим дээр суурилан тайлагнахыг үүрэг болгосон.<br><br>**Арван тав.**Татварын хууль тогтоомжийн шинэчлэл, түүнийг дагалдах Гаалийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд "ГТХ, ГТГТТХ-ийг өөрчлөх хэрэгцээ шаардлага, үндэслэл"-ийг тодорхойлох судалгааг мэргэжлийн судалгааны байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн, судалгааны тайланг танилцуулах уулзалт 2025.06.04-ний өдрийн 14.00 цагт ГЕГ-ын 4 давхрын уулзалтын өрөөнд зохион байгуулагдах тул Дэд дарга, ХБГ-ын дарга Даваасүрэн, ХШҮДАГ-ын дарга Төмөр-Очир, ТОГ-ын дарга Баярмаа, ХХ-ийн дарга Тамираа, БАҮХ-ийн дарга Чимгэрэл нар оролцсон. | | |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛТ 4: ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ | | | | | | | |
| 10 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | Нэгжийн эрсдэлийг таньж тогтоон ангилсан байна. | Улсын төсвийн орлого бүрдүүлэх, статистик мэдээ боловсруулах, дүн шинжилгээ хийхдээ эрсдлийг тооцон ангилж, энэ чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.<br>МТЗНХ-той 2024 оны намраас хамтран ажилласны үр дүнд импортын барааны гол урсгал, Монгол улс руу тээвэрлэгдэх чингэлэг болон шилжүүлэн ачилт, төмөр замын тээвэрлэлтээс шалтгаалан ачааны төвлөрөл бөгөнөрөл үүсч байдаг БНХАУ-ын Тяньжин боомт дахь чингэлэгийн ачааны татан авалт, төвлөрөл бөгөнөрөл үүсэж байгаа эсэх мэдээллийг сард 2-3 удаа авч, холбогдох арга хэмжээг авах саналын хамт Сангийн яаманд хүргүүлэн ажилласан. | 01.01-06.10 | 100 |
| 11 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Ажлын цаг ашиглалтын 2023 оны үнэлгээг өмнөх оны эхний хагас жилийнхээс бууруулахгүй ажиллана. | 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар ажиллавал зохих 111 өдөр, 888 цаг ажиллахаас 111 өдөр, 888 цаг ажилласан байна. Газрын дарга 2025 оны ээлжийн амралтын хоногоос 11 хоног амарсан. | 01.01-06.10 | 95 |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | Гадаад орны Засгийн газар, банк санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн хүрээнд нийлүүлсэн бараа, буцалтгүй тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад зориулсан сургалт | **Нэг**. Нийслэл дэх төрийн Аудитын газраас 2025.05 сард Гаалийн байгууллагын 2023, 2024 оны “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аудитын хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу шалгалт хийхтэй холбогдуулан ТОГ-аас ЗТГ, БДШГ-ын дарга, ГУАБ нарт болон гаалийн газар, хороодын дарга нарт “Чиглэл хүргүүлэх тухай” албан тоотыг хүргүүлж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж, архиваас баримт бичгийг гаргуулан, холбогдох мэдээллээр ханган хамтран ажилласан.<br>**Хоёр**. ГЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу БЦТ-ийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд ГЕГ-ын ХШҮДАГ-аас татвар орлого, хөнгөлөлт чөлөөлөлт, гарал үүслийн чиглэлээр дотоод аудит хийх ажлын бүрэлдэхүүнд ТОГ-ын ГУАБ Эрдэнэбат орж ажилласан.<br>**Гурав**. ГЕГ-ын даргын 2025.04.25 өдрийн 2025/04 дугаартай Татвар орлогын газрын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын удирдамжийн хүрээнд ХШҮДАГ-аас тус газрын үйл | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан байна. | ажиллагаанд дотоод аудитыг хийж хэрэгжүүлсэн. Чиг үүргийн хүрээнд холбогдох баримт бичгийг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.<br>Тухайлбал: Чиг үүргийн дагуу хийж буй ажлын танилцуулга, түүнд зарцуулагдаж буй цаг хугацааны судалгаа, авлагын далгэрэнгүй бүртгэлийн тодруулга, өр авлагын барагдуулалт, шийдвэрлэлт, хойшлуулсан татварын дэлгэрэнгүй судалгаа, түр горимын дансны үлдэгдэлийн дэлгэрэнгүй судалгаа, Сангийн яамны Төрийн сангийн газартай нийлдэг Гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг 2 оноор, төсөвт төвлөрүүлсэн орлогыг төрөл тус бүрээр гаалийн газар, хороодтой тооцоо нийлж баталгаажуулах талаар мөн CAIS, epayment, ehuulga гэх зэрэг ажлын программуудад хэрхэн хяналт тавь ажилладаг зэрэг мэдээлэл, баримт, судалгаа болон татварын чөлөөлөлт, тариф гарал үүслэл, орлогын дүн шинжилгээтэй холбоотой баримт бичгийг гаргаж өгсөн.<br>**Дөрөв.** Зохион байгуулсан сургалтууд:<br>2025.01.14-нд Бүрдүүлэлтийн цахим төвд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 зүйлд орсон өөрчлөлтийн талаарх сургалтыг зохион байгуулахад дарга, 6 ГУАБ, 49 ГУБ оролцсон. 2025.02.21- нд УБ хот дахь гаалийн газрын хурлын танхимд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт зориулсан анхан шатны сургалтанд 2 цагийн сургалтыг Татварын чөлөөлөлт сэдвээр ороход нийт 50 бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдсан.<br>2025.04.18 -нд Сургалтын төв дээр зохион байгуулагдсан бичиг баримтын ГУБ нарт зориулсан "Үнэлгээний мэргэшлүүлэх сургалт"-нд 2 цагийн сургалтыг Татварын чөлөөлөлт сэдвээр орсон. Нийт 40 ГУБ хамрагдсан.<br>2025.05.20-нд МУИС дээр зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт зориулсан анхан шатны сургалтанд 2 цагийн сургалтыг Татварын чөлөөлөлт сэдвээр орсон. Нийт 40 бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдсан.<br>2025.05.20-нд Сургалтын төв дээр зохион байгуулагдсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт зориулсан давтан сургалтанд 2 цагийн сургалтыг Татварын чөлөөлөлт сэдвээр орсон. Нийт 40 бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Тав**. Захиргаа, удирдлагын газар, Хүний нөөцийн хэлтэс зэрэг нэгжээс зохион байгуулсан сайн үйлс, хандив болон олон нийтийн, цаг үеийн ажил, арга хэмжээнд газрын хамт олон бүрэн хамрагдаж оролцсон. | | |
| 13. | Цахим нэг цонхны системийг бий болгох ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | 100 | Эхний хагас жилд:<br>1. Олон улсын зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажиллаж, гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргүүлнэ. | “Монгол улсын Гаалийн ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг ахисан түвшинд хүргэх” төслийн ажлын даалгавартай танилцаж, Эрсдэлийн удирдлагын хэлтэст дараах саналыг хүргүүлсэн.<br>**Нэг.** Гаалийн орлогын таамаглалын загварыг боловсруулахад тусгах санал: Төсөлд тусгагдсан өгөгдлийн агуулга, эрсдэлийн удирдлагын системийн хүрээнд дараах чиглэлүүдээр нэмэлт хөгжүүлэлт хийх боломжтой гэж үзэж байна. Үүнд: • Татварын орлогын таамаглалыг гаргахад хиймэл оюун ухаан дээр суурилсан загвар боловсруулах. Тухайлбал, сүүлийн 5–10 жилийн гадаад худалдааны статистик, импортын нийлүүлэлтийн урсгал, гадаад мөнгөн гуйвуулгын мэдээлэл, тээвэрлэлтийн мэдээлэл, тээвэр ложистикийн байдал, улирлын хэлбэлзэл, барааны бүтэц, тарифын өөрчлөлт, дэлхийн зах зээлийн өөрчлөлтийн нөлөөлөл зэрэг гадаад, дотоод мэдээллийг харгалзсан машин сургалтын загвар ашиглан орлогын төсөөлөл хийх; • Салбар, барааны ангилал, хил боомтын түвшинд задлан шинжлэх боломжтой BI (Business Intelligence) орчныг нэвтрүүлэх. Ингэснээр гаалийн байгууллага стратегийн түвшинд шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлнэ<br>**Хоёр.** Төслийн хүрээнд хийгдэх сургалтад эдийн засагч, төсөв хариуцсан албан хаагчдыг хамруулах: Гаалийн татварын төсөөлөл, анализ, төлөвлөлт хариуцсан эдийн засагчдыг өгөгдлийн шинжилгээ, Tableua dashboard, AI загварчлалын сургалтад хамруулах нь орлогын таамаглалыг илүү оновчтой болгоход хувь нэмэр оруулна.<br>**Гурав.** Мэдээлэл, өгөгдлийн уялдаа холбоо, солилцооны стандартчлалын санал: Гаалийн байгууллагаас улсын төсвийн гаалийн орлогын таамаглалыг илүү нарийвчлалтай гаргахын тулд Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо зэрэг төрийн байгууллагууд, мөн тээвэр, ложистик, худалдааны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага | 01.01-06.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах чиглэлд сургалтад хамрагдах | | | | 2025.02.07-ны хооронд хийгдэх ажлын чиглэлийг авсаны дагуу ГТГТТХ-д барааны ангилал, үнэлгээ, гарал үүсэл, тариф, БДШ-ын чиглэлээр өөрчлөлт оруулах хэсэгт ажилласан.<br><br>УБ хотын Худалдааны танхимаас зохион байгуулсан “Татварын шинэчлэл-Хувийн хэвшлийн оролцоо” Хэлэлцүүлэгт оролцсон.<br><br>ГЕГ-ын баталсан “Татварын хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээлэл цуглуулах, судалгаа хийх, санал боловсруулах нэгдсэн төлөвлөгөө”-ний 7-д тусгагдсан “ГТГТТХ-ийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эрх зүйн үр нөлөөг үнэлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх” ажлыг хариуцан ажилласан. | | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бие дааж уншиж судалсан байна. | Монгол Улсын Их Хурлын 2024.12.12-ны өдрийн хуулиар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан тул шинээр гарсан хууль тогтоомжийг судалсаны үр дүнд дараах ажлыг зохион байгуулсан:<br><br>1.Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголттой болохын тулд ХБГ, БАҮХ, ГТЛ, БЦТ-тэй хамтран уулзалтыг хийж, харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулсан.<br><br>2.ХХААХҮЯ-ны чиглэлийн газрын дарга, асуудал хариуцсан ажилтан, Мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хэд хэдэн удаагийн уулзалтыг хийсэн.<br><br>3.Засгийн газрын 2024.12.25-ны өдрийн 241, 242 тоот тогтоол “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” батлагдсаны дагуу Засгийн газрын “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 2023.01.25-ны өдрийн 35 дугаар тогтоолын 1 дэх заалтын “2025.01.01-ний өдрийн хүртэл” | 01.01-06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гэснийг "2026.01.01-ний өдөр хүртэл" гэж өөрчилсөн, Засгийн газрын "Авто бензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай" 2015.01.19-ны 18 дугаар тогтоолын 1 дэх заалтын "2025.01.01 -ний өдөр хүртэл" гэснийг "2026.01.01-ний өдөр хүртэл" гэж өөрчилсөн болно.<br><br>Иймд шинээр гарсан хууль тогтоомжийг судалж, өөрийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ БАУХ, Бүрдүүлэлтийн цахим төв, гаалийн газар, хороодод холбогдох чиглэлийг хүргүүлэн ажилласан. | | |

ТАЙЛАНГИЙН БИЕЛЭЛТ ОРУУЛСАН:

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .............................. /С.БАЯРМАА/

Огноо: 2025.06.10

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.БАЯРМААГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Татвар, орлогын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 59,2 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Татварын хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгохтой холбоотой “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж, Татварын багц хууль болон ГТГТТХ-д оруулах нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгаа хийх, мэдээлэл боловсруулах чиглэлд сургалтад хамрагдах | | 15 |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 15 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 13 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 12 |
| 6. | Харилцаа | 13 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |

| | | |
|---|---|---|
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо | | 13 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 59,2 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | – |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 87,2 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга .................... (Р.Отгонжаргал)

2025.06.25 .................... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Татвар, орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Баярмаа .................... (С.Баярмаа)

2025.06.10 .................... (огноо)